



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/368

Булган сум

**“Хангинахын шугуйн шагайн тойром”
эвент үйл ажиллагааг зохион байгуулах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.3, 8.1.7, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/03 дугаар тогтоолоор баталсан “Шинэ хөгжлийн зам” Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын соёл, спортын эвент үйл ажиллагааг 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. “Хангинахын шугуйн шагайн тойром” эвент үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, шаардагдах хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Хангинахын шугуйн шагайн тойром”-ын эвент үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг ажлын хэсгийн дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

4. Дээрх арга хэмжээнд шаардагдах 13,965,000 (арван гурван сая есөн зуун жаран таван мянга) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний “Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах” төсөл арга хэмжээнээс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



05 дугаар сарын 01-ны/ний өдрийн А/362 дугаар
Аймгийн Засаг даргын 2024 оны
захирамжийн 1 дүгээр хавсралт

“ХАНГИНАХЫН ШУГУЙН ТОЙРОМ 2024” ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга: Д.Алтаншагай (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Орлогч дарга: Г.Ариунболд (Аймгийн үндэсний Шагайн холбооны тэргүүн зөвшилцсөнөөр)

Гишүүд: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Г.Давааням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Г.Ганбаяр (Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа)
Ш.Баасандорж (Онцгой байдлын газрын дарга, хурандаа)
Г.Алдармөнх (Соёл, урлагийн газрын дарга)
П.Лхагва-Очир (Хутаг-Өндөр сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга: А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

05 дугаар сарын 21-ны/ний өдрийн А.1368 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

Аймгийн Засаг даргын 2024 оны

**“ХАНГИНАХЫН ШУГУЙН ТОЙРОМ 2024” ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ШАГНАЛЫН ЗАРДАЛ**

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Медаль	ш	81	15,000	1,215,000
2	Өргөмжлөл	ш	18	25,000	450,000
Хэсгийн дүн					1,665,000
Багийн харваа мөнгөн шагнал (насанд хүрэгчид)					
1	1-р байр	хүн	1	5,000,000	5,000,000
2	2-р байр	хүн	1	3,000,000	3,000,000
3	3-р байр	хүн	1	1,000,000	1,000,000
4	4-р байр	хүн	1	500,000	500,000
5	5-р байр	хүн	1	300,000	300,000
6	6-р байр	хүн	1	300,000	300,000
7	7-р байр	хүн	1	300,000	300,000
8	8-р байр	хүн	1	300,000	300,000
Хэсгийн дүн					10,700,000
Багийн харваа мөнгөн шагнал (ахмад)					
1	1-р байр	хүн	1	500,000	500,000
2	2-р байр	хүн	1	300,000	300,000
3	3-р байр	хүн	1	200,000	200,000
Хэсгийн дүн					1,000,000
Цуваа харваа (насанд хүрэгчид)					
1	1-р байр	хүн	1	300,000	300,000
2	2-р байр	хүн	1	200,000	200,000
3	3-р байр	хүн	1	100,000	100,000
Хэсгийн дүн					600,000
Цуваа харваа (ахмад)					
1	1-р байр	хүн	1	Медаль өргөмжлөл	Медаль өргөмжлөл
2	2-р байр	хүн	1	Медаль өргөмжлөл	Медаль өргөмжлөл
3	3-р байр	хүн	1	Медаль өргөмжлөл	Медаль өргөмжлөл
Хэсгийн дүн					-
Нийт дүн					13,965,000